

"ТЭГ ХАЯГДАЛ" БАГЦЫН ТУХАЙ

ЭКОСУМ – ХУВИЛБАР 3 – 2024 ОНЫ 3 САР

Энэхүү багцыг Европын Холбооны санхүүжилттэй "Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төслийн хүрээнд боловсруулсан ба энд илэрхийлсэн үзэл бодол нь Европын Холбооны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Экосум ТББ нь 2018 оноос хойш орон нутагт хог хаягдлаа зохистой зохицуулах тогтолцоог бий болгох мөн үндэсний хэмжээнд Тэг хаягдлын бодлогыг баримтлан ажиллахын төлөө зорин ажилласаар ирсэн. Энэ хугацаанд хуримтлуулсан туршлага болон олон улсын Тэг хаягдлын хөдөлгөөнөөс олж авсан мэдлэгээ хуваалцахын тулд олон тайлан, судалгааны ажил, бичлэгүүдийг бэлтгэн гаргасан билээ.

Энэхүү багц нь орон нутгийн удирдлагууд, ТББ-ууд, иргэдийн хөдөлгөөнүүд болон идэвхтэн зүтгэлтнүүдэд Тэг хаягдлын талаар суралцаж, орон нутагтаа хог хаягдлын менежментээ сайжруулаад зогсохгүй үндэсний хэмжээнд системийн өөрчлөлтийн төлөө нэгдэн ажиллахад нь дэмжлэг болох зорилготой юм.

Тус багцын үндсэн бичиг баримт нь 2024 оны 2 дугаар сард манайхаас гаргасан "Монгол Улс Тэг хаягдлын зарчмаар замнах нь - Үндсэн мэдээлэл, зөвлөмжүүд" нэртэй тайлан бөгөөд үүнд Тэг хаягдлын ойлголттой холбоотой бүхий л гол гол мэдээллийг маш олон эх сурвалж, баримтуудын хамт багтаасан болно. Уншигчид хамгийн түрүүнд уг тайланг сайтар уншиж танилцаад тодорхой сэдвүүдийг нарийвчлан авч үзсэн бусад тайлангуудыг судлах нь зүйтэй.

Энэхүү тайланг дагалдах PowerPoint файлыг мөн бэлтгэсэн бөгөөд доторх агуулгыг тайлантай ижил дарааллаар зохион байгуулсан тул сургалт зохион байгуулахдаа тайлангаа дэмжих материалаар хялбар ашиглах боломжтой юм.

Бусад бүх тайлан, бичлэгүүдийг "дэмжих материал" хавтаст оруулсан байгаа. Энэ хавтсыг ч мөн тайлантай ижлээр зохион байгуулсан тул хэрэглэгчид тайланд эх сурвалжаар оруулсан үндсэн тайлангуудыг төвөггүй олох боломжтой юм.

Хог хаягдлаа зохистой зохицуулах тогтолцоотой болохоор хичээн ажиллаж буй орон нутгийн удирдлага, иргэдэд зориулсан бичиг баримтуудыг 7 дугаар хавтаст ("Монгол Улсад хог хаягдлаа зохистой зохицуулах нь") багтаав. Дэлгэрэнгүй гарын авлагаас гадна хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, хог хаягдал зохицуулах төв байгуулах, хог хаягдлын төсвөө тооцоолох, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах зэрэгтэй холбоотой маш олон хэрэгтэй материалууд энд бий.

Багцын агуулгыг дараагийн 2 хуудаснаас харна уу. Дийлэнх нь Монгол, Англи хэл дээр байгаа боловч цөөн хэд нь энэ хоёр хэлний зөвхөн аль нэг дээр байгааг анхаарна уу.

БАГЦЫН АГУУЛГА

I. Экоsum танилцуулга:

- Экоsum-ын вэб хуудас (интернэт холбоос www.ecosoum.org/mn).
- Экоsum-ын танилцуулга бичлэг (YouTube бичлэгийн холбоос).

II. Монгол Улс Тэг хаягдлын зарчмаар замнах нь - Үндсэн мэдээлэл, зөвлөмжүүд:

1. Монгол Улс Тэг хаягдлын зарчмаар замнах нь - Үндсэн мэдээлэл, зөвлөмжүүд (PDF).
2. Сургалтын PowerPoint, бичлэгүүд:
 - 2.1. 'Монгол Улсаа хоггүй орон болгоё' сургалтын материал (PowerPoint).
 - 2.2. Сургалтанд ашигладаг бичлэгүүд (YouTube / Facebook / Google Drive бичлэгүүдийн 15 холбоос).

III. Нэмэлт материалууд:

1. Хуванцрын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллүүд:
 - 1.1. Plastic & Health. The Hidden Costs of a Plastic Planet (PDF).
 - 1.2. Breathing Plastic. The Health Impacts of Invisible Plastics in the Air (PDF).
 - 1.3. The Story of Stuff төслийн бичлэгүүд:
 - 1.3.1. Эд зүйлсийн түүх (YouTube бичлэгийн холбоос).
 - 1.3.2. Хуванцрын түүх:
 - Хуванцрын түүх – Богино бичлэг (YouTube бичлэгийн холбоос).
 - Хуванцрын түүх – Бүрэн хэмжээний баримтат кино (Google Drive-т байрших бичлэгийн холбоос).
2. Хог хаягдлын хямралын хуурмаг шийдлүүд:
 - 2.1. Тэг хаягдал, тойрог эдийн засаг. Урагшлах зам:
 - Тэг хаягдал, тойрог эдийн засаг. Урагшлах зам (PDF).
 - Тэг хаягдал болон тойрог эдийн засаг. Ярилцлага (YouTube бичлэгийн холбоос).
 - 2.2. Хуванцрын шийдлүүдийн тойм шүүмж (PDF).
3. Хог хаягдал шатааж эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой сөрөг үр дагаврууд:
 - 3.1. Хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх арга ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэх шаардлагатай юу? (PDF).
 - 3.2. Хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх төслийн саналыг үнэлэх зааварчилсан гарын авлага (PDF).
 - 3.3. Trashed (Фэйсбүүк бичлэгийн холбоос).
- 4-5. Тэг хаягдал түүний ач холбогдол:
 - Монгол улс Тэг хаягдлын зарчмаар замнах нь (PDF).
6. Үйлдвэрлэгчийн хариуцлагыг хүлээлгэх нь:
 - Бидний хог хаягдлыг хэн үйлдвэрлэдэг вэ? Брэнд аудитын тайлан (PDF).
 - Брэндийн аудитын мэдээ баримт (Excel файл).

- Бидний хог хаягдлыг хэн үйлдвэрлэдэг вэ? (YouTube бичлэгийн холбоос).
- Хог хаягдлын хямралыг шийдвэрлэхийн тулд юу хийх ёстой вэ? (YouTube бичлэгийн холбоос).

7. Монгол Улсад хог хаягдлаа зохистой зохицуулах нь:

7.1. Гарын авлага - Сумын түвшинд хог хаягдлаа зохицуулах зохистой тогтолцоог хэрхэн бий болгох вэ (PDF).

7.2. Хог хаягдлын суурь судалгаа:

7.2.1. Өрхийн зуны хог хаягдлын бүцтийн судалгаа (PDF).

7.2.2. Өрхийн өвлийн хог хаягдлын бүтцийн судалгаа (PDF).

7.2.3. Хог хаягдлын бүтцийн судалгааны үндсэн баримтууд (PDF).

7.2.4. Хишиг-Өндөр сумын хог хаягдлын менежментийн суурь судалгаа (PDF).

7.3. Хог хаягдал зохицуулах схем:

7.3.1. Бид Хишиг-Өндөр суманд хогоо хэрхэн зохицуулдаг вэ? (YouTube бичлэгийн холбоос).

7.3.2. Хог хаягдал зохицуулах ерөнхий төлөвлөгөө:

→ Хог хаягдал зохицуулах ерөнхий төлөвлөгөөний загвар (Word файл).

→ Хишиг-Өндөр сумын хог хаягдал зохицуулах схемийн зөвлөмж тайлан (PDF).

7.3.3. Хог хаягдал зохицуулах төвийн загвар дизайнд санал болгох хувилбар:

→ Хог хаягдал зохицуулах төвийн дизайны загвар зураг (PDF).

→ Хог хаягдал зохицуулах төвд шаардлагатай төсвийн тооцоо (Excel файл).

7.3.4. Булган аймгийн хог хаягдал зохицуулах ерөнхий төлөвлөгөөнд хүргэх зөвлөмж тайлан (PDF).

7.4. Хог хаягдал зохицуулах төсөв:

→ Сумын хог хаягдал зохицуулах төсвийг хэрхэн тэнцүүлэх вэ? (PDF).

→ Сумын хог хаягдал зохицуулах тогтолцооны төсвийн тооцоолуур (Excel файл).

→ Хог хаягдал зохицуулах төсвийг хэрхэн тэнцүүлэх вэ? (YouTube бичлэгийн холбоос).

7.5. Гэртээ хогоо хэрхэн ангилах вэ:

7.5.1. Гарын авлага - Гэртээ хогоо хэрхэн ангилах вэ? (PDF).

7.5.2. Сургалт - Гэртээ хогоо хэрхэн ангилах вэ? (PowerPoint).

7.5.3. Гэртээ хогоо хэрхэн ангилах вэ? (YouTube бичлэгийн холбоос).

7.5.4. Хишиг-өндөр сумын иргэд хог ангилалтын талаар (YouTube бичлэгийн холбоос).

8. Хуванцрын олон улсын гэрээ:

→ Хуванцрын олон улсын гэрээ яагаад зайлшгүй шаардлагатай вэ (YouTube бичлэгийн холбоос).

→ Хуванцрын асуудлыг энэ гэрээгээр шийдвэрлэх боломжтой (Фэйсбүүк бичлэгийн холбоос).